



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/159

Булган сум

### Аймгийн аюулгүйн нөөцийн тэжээлийн үнийг хөнгөлөх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын “Шуурхай бүлэг III”, аймгийн Онцгой комиссын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн 70 тн тэжээлийн 1 тонны үнийг 450,000 (дөрвөн зуун тавин мянга) төгрөгөөр худалдан борлуулах буюу 50 хувиар хөнгөлсүгэй.

2.Тэжээлийн үнийг хөнгөлж байгаатай холбогдуулан сумдад олгосон тэжээлийн тооцоог шинэчлэхийг “Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК (Б.Одхүү)-д даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/74 дугаар захирамжийн тэжээлийн үнэтэй холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

